



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.06 № 06/89 УАГ-САГ/2012/ЗА-04

Зөрчлийг арилгах тухай


Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2011, 2012 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн аудитаар Хүнс, хөдөө аж ахуйн сайд (хуучин нэрээр)-ын 2007 оны 142 дугаар тушаалаар Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас тус яамны нэр бүхий 7 ажилтанд 5 жилийн хугацаатай нийт 155.0 сая төгрөгийн орон сууцны хүүгүй зээл олгож, гэрээний хугацаа 2012 оны 11 дүгээр сарын 30-нд дууссан боловч зээлийг төлүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5.1.4-т "санхүү, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 14.1.1-д "Зээл авах, зээл олгох, зээлийн төлбөр гүйцэтгэх, зээл хувиргахыг хориглоно", Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.6.8-д "батлагдсан төсөв, орон тооны дээд хязгаартаа багтаан яамны төсвийн хөрөнгийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "... тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дээр дурьдсан 155.0 сая төгрөгийг П.Улаанхүү, Л.Баяртулга, У.Бямбасүрэн, С.Магнайсүрэн, Л.Өлзийбаяр, Г.Наранцэцэг, Л.Зол нараар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь төсвийн орлогын 900000601 дүгээр дансанд 2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх; (Үндэсний аудитын газрын 2008 оны 12 дугаар актын дагуу)
2. Хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд гэрээний 3.1.3, 5.4-т заасны дагуу хариуцлага тооцох, хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх;
3. Албан шаардлагын биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж, 2013 оны 5 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг ТЭДС-гийн гүйцэтгэх захирал Д.Од, хуулийн зөвлөх Д.Бат-Эрдэнэ, ерөнхий нягтлан бодогч Г.Батцэцэг нарт хариуцуулав.

Санхүүгийн аудитын газрын
Нэгдүгээр хэлтсийн захирал



С.Оюунгэрэл